



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 8/03

Бэрх хот

Цалингийн хэмжээг  
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, “Төрийн албаны тухай” хуулийн 57 дүгээр зүйлийн 57.2.4 дэх заалт, “Хөдөлмөрийн тухай” хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх заалт, Засгийн газрын “Журам батлах тухай” 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Засгийн газрын “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол, Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотын Соёлын ордны захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Одын үндсэн цалингийн хэмжээг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт ТҮСБ-5 албан тушаалын 1.637.000 төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 5 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдэл 40 хувиар шинэчлэн тогтоож олгосугай.

2. Б.Одын цалинг тогтоосон хувь, хэмжээгээр холбогдох хууль, дүрэм журмын дагуу бодож олгохыг соёлын ордны нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Б/05 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ЗАХИРАГЧИЙН  Ч.ӨНХЖАВХЛАН



232601006